# ДОРНОД АЙМГИЙН БАЯНДУН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЦАГААН ЧУЛУУТЫН ХООЛОЙН ДУНД ХЭСЭГ ” НЭРТЭЙ АЛТНЫ ШОРООН ОРДЫН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

*Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-003108*
*Регистрийн дугаар:2763788*

**Хянасан:**

БОУАӨЯ-ны ХБОБНУГазрын мэргэжилтэн: ......................................

Дорнод аймгийн БОГазрын мэргэжилтэн: ........................................

**Биелэлтийг тайлагнасан:**

“ХОТУ” ХХК-ний захирал:............................Ш.Түвшинжаргал

Байгаль орчны мэргэжилтэн:.....................Э.Мөнгөнтуяа

2024 он

# Агуулга


1. ОРШИЛ .....5

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....5

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....9

*3.1.Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ* .....9

*3.2.Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ* .....15

*3.3.Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт* .....19

*3.4.Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд* .....23

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....26

5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....29

6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....31

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....32

8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....32

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....32

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....36

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....37

12. ДҮГНЭЛТ .....38

**Зургийн жагсаалт**

Зураг № 1 Талбайн байршлын тойм зураг ........ 6
Зураг № 2 Уурхайн олборлолтын явц ........ 6
Зураг № 3 Уурхайн кемп ........ 8
Зураг № 4 Уурхайн кемп ........ 9
Зураг № 5 Ажилчдын хоолны газар ........ 9
Зураг № 6 Зам усалгааны ажил хийгдэж буй байдал ........ 11
Зураг № 7 Уурхайн ажилчдын кемпд тоосжилтын хэмжилт хийж буй байдал ........ 11
Зураг № 8 Уурхайн карьерт агаарын дээжний хэмжилт хийж буй байдал ........ 12
Зураг № 9 Уурхайн тээврийн замд агаарын хэмжилт хийж буй байдал ........ 12
Зураг № 10 Тоосжилт үүсэх, хөрс хамгаалах зорилгоор кеп доторх явган хүний замыг тохижуулсан байдал ........ 13
Зураг № 11 Хурдны хязгаарын тэмдэгнүүд ........ 15
Зураг № 13 Уурхайн технологийн усны нуур ........ 17
Зураг № 12 Үерийн ус болон галын аюулаас хамгаалах даланг байгуулсан байдал ........ 17
Зураг № 14 Цэврийн нуурнаас дээж авч буй байдал ........ 17
Зураг № 15 Бохирын нуурнаас дээж авч буй байдал ........ 18
Зураг № 16 Кемпээс ундны усны дээж авч буй байдал ........ 18
Зураг № 17 Уурхайн шимт хөрс ........ 20
Зураг № 18 Шимт хөрснөөс дээж авч буй байдал ........ 20
Зураг № 19 ШТС талбай ........ 21
Зураг № 20 ШТС-ын талбайгаас хөрсний дээж авч буй байдал ........ 21
Зураг № 21 Засварын талбай ........ 22
Зураг № 22 Засварын талбайгаас хөрсний дээж авч буй байдал ........ 22
Зураг № 23 Ургамлын мониторинг судалгааны явц ........ 25
Зураг № 24 Галын сарааг ШТС талбайд байршуулсан байдал, уурхайн техник бүрд галын аюулгүй байдлыг хангаж буй байдал ........ 26
Зураг № 25 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил ........ 27
Зураг № 26 Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал ........ 28
Зураг № 27 Уурхайн олборлолтын явц 2024.09.29 ........ 28
Зураг № 28 Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал 2024.10 сар ........ 29
Зураг № 29 Хашааны зураг төсөл ........ 30
Зураг № 30 Хашааны ажлын явц ........ 30
Зураг № 31 Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийсэн хашаа ........ 31
Зураг № 32 Хуурай хог хаягдлын цэг ........ 33
Зураг № 33 Хуванцар хаягдал, ашигласан акумляторыг ангилдаг байдал ........ 33
Зураг № 34 Шатах тослох материалын хаягдал ........ 34
Зураг № 35 Хаягдал дугуй ........ 34
Зураг № 36 Хатуу хог хаягдлаа ачиж буй байдал ........ 35
Зураг № 37 Хаягдал тосыг цуглуулж буй байдал ........ 35
Зураг № 38 Байгаль орчны аудитын явц ........ 38

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт № 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт ........ 11
Хүснэгт № 2 Уурхайн агаарын хэмжилтийн дүн........ 13
Хүснэгт № 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт ........ 16
Хүснэгт № 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт........ 19
Хүснэгт № 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт ........ 23
Хүснэгт № 6 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны төрөл ........ 26
Хүснэгт № 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт........ 32
Хүснэгт № 8 Орчны хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн ажил........ 36
Хүснэгт № 9 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт........ 37

***Хавсралт материалын жагсаалт***

*Хавсралт № 1 Шимт хөрсний дээжний хариу ........ 40*
*Хавсралт № 2 ШТС болон засварын талбайн хөрсний хүнд металлын шинжилгээний дүн. 41*
*Хавсралт № 3 Бохирын нуурын усны хүнд металлын шинжилгээний дүн ........ 42*
*Хавсралт № 4 Бохирын нуурын усны химийн шинжилгээний дүн ........ 43*
*Хавсралт № 5 Цэвэрийн нуурын усны химийн шинжилгээний дүн........ 44*
*Хавсралт № 6 Цэвэр нуурын усны химийн шинжилгээний дүн........ 45*
*Хавсралт № 7 Ундны усны бактерлогийн шинжилгээний дүн ........ 46*
*Хавсралт № 8 Ундны усны химийн шинжилгээний дүн ........ 47*
*Хавсралт № 9 Сав газрын даргын тушаал ........ 48*
*Хавсралт № 10  Ус ашиглах гэрээ........ 52*
*Хавсралт № 11 Ус ашиглуулах дүгнэлт ........ 57*
*Хавсралт № 12 Ахуйн ус ашиглах гэрээ........ 58*
*Хавсралт № 13 Нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт........ 59*
*Хавсралт № 14 Хог хаягдал гэрээ ........ 61*
*Хавсралт № 15 Хог хаягдлын төлбөр төлсөн баримт........ 62*
*Хавсралт № 16  Хог хаягдлын бүртгэл ........ 63*
*Хавсралт № 17 Байгаль орчны хяналт шинжилгээний тайлан........ 64*
*Хавсралт № 18 Байгаль орчны аудитын ажлын явц........ 65*
*Хавсралт № 19 Техникийн хаягдал тос нийлүүлэх гэрээ ........ 68*
*Хавсралт № 20 Аюултай хог хаягдал тээвэрлэх, боловсруулах тусгай зөвшөөрөл........ 69*
*Хавсралт № 21 2024 оны нөхөн сэргээлт хүлээн авсан акт ........ 72*
*Хавсралт № 22 2024оны БОМТБиелэлтийн дүгнэх хуудас ........ 73*

# 1. ОРШИЛ

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан нь 2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний заалтуудыг ханган ажиллахад чиглэсэн болно.

“Цагаан чулуут хоолойн дээд хэсэг” нэртэй 380.2га бүхий MV-003108 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын Кадастарын хэлтсийн даргын 2016 оны 10-р сарын 10-ны өдрийн 51 тоот шийдвэрээр “ХОТУ”ХХК-д шилжүүлсэн байна. Цагаан чулуут хоолойн дунд хэсгийн алтны шороон ордын доод давхарга нь алттай дан давхаргаас бүрдэх ба харьцангуй бага уналтай тэгш маягийн U хэлбэрийн хөндийг дагаж тогтсон, аллювиаль-пролювиаль гаралтай голын сэвсгэр хурдсанд хуримтлагдсан, тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, III бүлгийн орд юм. Ордын ашигт давхарга суналын дагуу тогтоогдсон бөгөөд ерөнхийдөө тууз хэлбэрийн тогтоцтой алт агуулсан хурдас нь нийлмэл тогтоцтой, дунд зэрэг мөлгөржсөн, 700м урттай, дундаж өргөн 60м, дундаж гүн 21м байна.

# 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Газар зүйн байршил: “Цагаан чулуут хоолойн дунд хэсэг” нэртэй MV-003108 тоот ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй судалгааны талбай нь засаг захиргааны хуваариар Монгол улсын зүүн хойд хэсэг, Дорнод аймгийн Баяндун сумын нутагт харьяалагдах бөгөөд улсын геодезийн нэгдсэн номинклатурын M-49-95, 96 хавтгайд байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 704 км, Баяндун сумаас хойд зүгт 35орчим километрийн зайнд байрлана.




*Зураг № 1 Талбайн байршлын тойм зураг*



*Зураг № 2 Уурхайн олборлолтын явц*

***2024 онд явагдах уулын ажил, ажиллах горим***

- ✓ **Ажиллах горим.**

Уурхай нь 2024 оны 03-р сараас эхлэн бэлтгэл ажил эхлүүлж 4-р сарын 1-ээс 9-р сарыг дуустал ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасны дагуу тооцон 180 хоног ажиллахаар төлөвлөв.

- ✓ **2024 онд явагдах уулын ажил.**

2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр цагаан чулуут хоолойн доод давхаргын 1-В, 2-В, 3-В гэсэн блокуудыг олборлоно. Энэ онд 691.5 мян.м3 хөрс хуулж, химийн цэврээр 18.4 кг алт бүхий 48.2 мян.м3 элс олборлоно. Энэ онд уурхайн урт 490 м, өргөн дунджаар 100 м, уурхай нийт 5 га талбайг эзэлж байна.

- ✓ **Үржил шимт хөрс хуулалт.**

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

- ✓ **Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажил.**

Алт агуулсан элсний тогтоц тэгш тогтвортой, гүн бага зэрэг дотоод овоолгоор төлөвлөх таатай нөхцөл байгаа тул шимт хөрсийг түрж үүсэх карьер дагуу овоолж, ашиглагдсан хоосон орон зайг хөрсөөр нөхөн дүүргэлт хийж дотоод овоолго хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хамт хийнэ. Ил уурхайн хөрсийг олборлосон орон зайг дүүргэх зорилгоор дотоод овоолгод байршуулна. Хөрс тээвэрлэлтийн ажилд HOWO маркийн 50 тн даацтай автосамосвал ажиллах ба тээвэрлэлтийн дундаж зай 0.5 км байна.

- ✓ **Элс олборлолтын ажил**.

Өлийн голны алтны шороон ордын элс шаварлаг их байгаа тул угаан баяжуулахад гүн болон нам дүүргэлтийн шлюз бүхий УГ-80 маркийн угаах төхөөрөмж ажиллаж шлихийн алтыг гаргана. 2024 онд нийт хугацаанд 0.52 гр/м3 агуулгатай 212.6 мян.м3 элсийг 89.5%-ийн металл авалттайгаар баяжуулж химийн цэврээр 99.16 кг (сорьц 764) алт үйлдвэрлэнэ.

- ✓ **Ус хангамж**

Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор уурхайн технологийн усан хангамжид хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашиглана. Алт олборлож байгаа уурхайнуудын туршлага, үүсмэл нуурын шүүрэлт, усны ууршилт, алдагдал, ордын талбайтай зэргэлдээ олборлолт явуулж байгаа ордын нууруудын шүүрэлт зэргийг үндэслэн шаардагдах усны 15%-ийг цэвэр усаар сэлбэх ба 85%-ийг технологийн эргэлтийн усаар хангах боломжтой байна. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай учир 1 м3 элс угаахад 2.11 м3 ус хэрэглэхээр тооцоолов.

Угаах процесст зарцуулах цэвэр усны хэмжээ 2024 онд 15.25 мян.м3 байна. Нийт зарцуулагдах усны 85%-ийг эргэлтэд оруулж 15%-ийг цэвэр усаар сэлбэнэ. Технологийн усыг эргэлтийн усан санд хуримтлуулан тунгааж, процесст эргүүлэн хэрэглэнэ.

- ✓ **Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй.**

Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

- ✓ **Шатах тослох материалын агуулах.**

ШТМ хадгалахад зориулж 50тн-ын ган сав 3 ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэнэ. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

***Сэлбэг материалын агуулах.***

Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байна.



*Зураг № 3 Уурхайн кемп*



*Зураг № 4 Уурхайн кемп*



*Зураг № 5 Ажилчдын хоолны газар*

## 3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“ХОТУ” ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

*3.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө. Уулын ажилд хамрагдах тээврийн *хэрэгслүүд байна.* | Уурхайн дарга | Тээврийн хэрэгслийн төлбөр, татварыг бүрэн төлж ажилласан. |
| 2. | Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг  тогтмол усалж байна. | Уурхайн дарга | Автозам ба овоолго, ажлын талбайг тогтмол услан, засч, тэгшилж ажилласан. Уурхайн талбай доторх замуудад нэмэлтээр хурдны хязгаарын 5, 20, 40, тэмдгүүдийг байрлуулсан. |
| 3. | Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ. | Захирал | Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав. |
| 4. | Уурхайд ажиллаж байгаа машин техникийн кабин доторх агааржуулах төхөөрөмж, хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч бүхээгт тоос орохгүй болгох арга хэмжээ авч байх | Уурхайн дарга | 100, 250, 500, 1000 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байсан. Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн. |

*Хүснэгт № 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*



*Зураг № 6 Зам усалгааны ажил хийгдэж буй байдал*



*Зураг № 7 Уурхайн ажилчдын кемпд тоосжилтын хэмжилт хийж буй байдал*



*Зураг № 8 Уурхайн карьерт агаарын дээжний хэмжилт хийж буй байдал*



*Зураг № 9 Уурхайн тээврийн замд агаарын хэмжилт хийж буй байдал*



*Зураг № 10 Тоосжилт үүсэх, хөрс хамгаалах зорилгоор кеп доторх явган хүний замыг тохижуулсан байдал*

*Хүснэгт № 2 Уурхайн агаарын хэмжилтийн дүн*

| № | Байршил | Сар өдөр | Хүхэрлэг хий /$SO_2$/ мг/м$^3$ | Азотын хий /$NO_2$/ мг/м$^3$ | Тоосны агууламж PM10 мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ | Чийгшил |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Уурхай хотхон | IX/29 | 0.029 | 0.038 | 1 | 40 | |
| 2. | Карьер | IX/29 | 0.026 | 0.042 | 4 | 42 | max42.4% min17.4% |
| 3. | Тээвэрлэлтийн зам | IX/29 | 0.058 | 0.078 | 3 | 42 | |
| | **MNS 4585:2016 стандарт** | **-** | **0.450** | **0.200** | **50** | **60.0** | 40-60% |


ЗОГС


30


40




*Зураг № 11 Хурдны хязгаарын тэмдэгнүүд*

*3.2. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ*

Усны нөөцийг хамгаалах үүднээс технологит ашиглах усны хэмжээг бага байлгах үүднээс анхаарч ажилласан. Баяжуулах буюу элстэй шороог угаахад хэрэглэж буй усыг 15%-ийг сэлбэн 85%-ийг эргүүлэн ашигласан.

*Хүснэг № 3 Усан орчны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Сав газартай гэрээ байгуулан ус ашиглах дүгнэлт гаргуулах | Компанийн захирал | Сав газартай байгуулсан гэрээ болон ус ашиглах дүгнэлтийг хавсаргав. |
| 2. | Уурхайгаа тойруулан үерийн далан багуулах | Уурхайн дарга | Үерийн далан байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хийсэн ажлын зураг оруулав. |
| 3. | Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх | Компанийн захирал | Ундны усанд химийн болон бактерлогийн шинжилгээ, технологийн нуурын усанд бохир усны хими болон хүнд металлын шинжилгээг “Монгол Ус”ТӨҮГ-ийн “Усны лаборатор”-д шинжлүүлсэн. Шинжилгээний хариуг хавсралтад оруулав. |



*Зураг № 13 Уурхайн технологийн усны нуур*





*Зураг № 12 Үерийн ус болон галын аюулаас хамгаалах даланг байгуулсан байдал*



*Зураг № 14 Цэврийн нуурнаас дээж авч буй байдал*



*Зураг № 15 Бохирын нуурнаас дээж авч буй байдал*



*Зураг № 16 Кемпээс ундны усны дээж авч буй байдал*

*Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

*Хүснэгт № 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

| № | Төлөвлөгөө | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Газар эзэмших гэрээгээ сумын ЗД-тай байгуулах, төлбөрөө төлөх | Компанийн захирал | 2024 оны 2-р сард газрын гэрчилгээгээ гаргуулахаар Баяндун суманд хүсэлтээ өгсөн. Баяндун сумын газрын захирамж гарсан бөгөөд Хэнтий аймгийн мэдээллийн санд бүртгүүлэх гэсэн ажлын явцтай байна. |
| 2. | Шимт хөрсний нөөц бий болгоход стандартын дагуу овоолж, ургамалжуулан хадгалах | Уулын мастер | Шимт хөрсийг стандартын дагуу овоолго үүсгэн хадгалж байна. Олон жил хадгалахгүй учир ургамалжуулах шаардлагагүй гэж үзсэн. |
| 3. | Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулах | Уурхайн дарга | Засварын талбайгаас өөр газарт тос масло солих ажлыг хориглосон. Засварын талбайн хөрсийг “Ханлаб”-ын хөрсний хүнд металлын шинжилгээнд өгсөн. Шинжилгээний дүн стандарт хэмжээнд байна. |



*Зураг № 17 Уурхайн шимт хөрс*



*Зураг № 18 Шимт хөрснөөс дээж авч буй байдал*



*Зураг № 19 ШТС талбай*



*Зураг № 20 ШТС-ын талбайгаас хөрсний дээж авч буй байдал*



*Зураг № 21 Засварын талбай*



*Зураг № 22 Засварын талбайгаас хөрсний дээж авч буй байдал*

### *3.3. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд*

*Хүснэгт № 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт*

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Олон салаа зам гаргахгүй байх | Уурхайн дарга | Өглөө бүрийн ажлын зааварчилгаанд заавар өгдөг. |
| 2. | Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхонд байрлуулна. | Уурхайн дарга | Галын аюулгүй байдлыг хангаж галын сараа байрлуулав. Мөн техник бүрийн галын аюулгүй байдлыг хангаан ажиллаж байсан. |

Орд орчмын ургамлын мониторинг судалгааг байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Газар чандмань”ХХК-аар гүйцэтгүүлсэн. Тусгай зөвшөөрлийн талбай орчмын ургамалжилт, ургамлын аймгийн одоогийн төлөв байдалд байгаль орчны суурь үнэлгээг хийхийн тулд хээрийн судалгааг явуулын аргаар гүйцэтгэсэн. Тухайн нутгийн ургамлын аймгийн зүйлийн бүрдэл, тэдгээрийн онцлогийг илрүүлэх, ургамлын аймгийн онцлог, ургамлын аймгийг бүрдүүлэгч зүйлийн статусыг тогтоох (ховор, нэн ховор, эндемик, субэндемик г.м), фото зураг координатаар баталгаажуулах, ургамалжилтын бичиглэл үйлдэж бүлгэмдлийг тодорхойлох зорилготой ажилласан.

Судалгааны талбайн ургамлын аймаг:

Төслийн ургамалжилт, ургамлын аймгийн судалгаа ургамалжилтын хэвшинж бүрт сөөгөн ташингыг 5x5 м-ийн талбайд, ургамлын бичиглэлийг 1x1 м-ийн талбайд Раменский, Друдьегийн аргаар үйлдэж ерөнхий бүрхэц, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлов. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг В.И.Грубов (1982)-ийн түлхүүр бичгээр тодорхойлон, монгол нэрийг Н.Өлзийхутаг (1983) ашиглав.

Тухайн нутагт ургамалжилтын хувьд уулсын арын нам уул толгодын хажуугийн хар хүрэн, нугат-цэвдэгт хөрстэй газрын өвслөг ургамалт энгэр хажуугийн доод бие, голын эхний хөндий, уулын ам дагасан ялзмагжсан ширэгт хөрстэй нам газраар хар шороон ба нугат хүрэн хөрсөн дээр тохиолдох нам уулсын зүр өвст нугын хээр, голын ай сав газрын жижиг голуудын адаг орчмын татмын намагжсан хэсгээр тохиолдох нугат-намгийн цэвдэгт, заримдаа ялихгүй хужирлаг хөрстэй газрын бургас оролцсон үетэн-улалжит намагжсан нугын ургамалжилттай.

Нам уулын зүр өвст нугын хээрийн бүлгэмдэл. Энэ бүлгэмдэлд 23 зүйл ургамал ургаж байгаагаас сөөгөн ташингын тусгагийн бүрхэц 2%, дундаж өндөр нь 0.5 м. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 70%, ургамлын дундаж өндөр 30 см байх ба зонхилогч ургамал нь

Сибирь Зүр өвс, Шеллийн Бутнуур, Байгаль Хялгана, Дэрвээн Тарна, Одой Далан түрүү, Ацан Цахилдаг, Бага Хумхаал, Зургаадай Зогдор өвс, Буурал Гандбадраа, Эгэл цагаантүрүү зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэнэ.

Татмын намагжсан хэсгээр тохиолдох нугат-намгийн цэвдэгт, заримдаа ялихгүй хужирлаг хөрстэй газрын бургасан шугуй оролцсон үетэн-улалжит намагжсан нугын бүлгэмдэл. Энэ бүлгэмдэлд 17 зүйл ургамал ургаж байгаагаас Сөөгөн хусны тусгагийн бүрхэц 20%, дундаж өндөр нь 0.5-1 м. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 80%, ургамлын дундаж өндөр 28 см байх ба зонхилогч ургамал нь Цэврүүт Улалж, Ипполитын Зэгс, Завсрын Гурвалж, Гурванцэцэгт Химдэг, Дорнодын Тор өвс, Орхигдмол Сорвоо, Аятайхан Шанд өвс зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэнэ.

Энгэр хажуугийн доод бие, голын эхний хөндий, уулын ам дагасан ялзмагжсан ширэгт хөрстэй газрын бургасан торлог нь ашиглалтын талбайн ургамалжилтын дээрх бүлгэмдлүүдтэй хослон ургана. Энэ бүлгэмдэлд 25 зүйл ургамал ургаж байгаагаас сөөгөн ташингын тусгагийн бүрхэц 35%, дундаж өндөр нь 0,7-1,5 м. Өвслөг бүрхэвчийн тусгаг бүрхэц 70%, ургамлын дундаж өндөр 30 см байх ба зонхилогч ургамал нь Шмидтийн Улалж, Нугын Биелэг өвс, Ахарсорт Арвай, Монгол Улаантолгойт, Эмийн Сөд, Хулганын Гиш зэрэг ургамал бүлгэмдэл үүсгэнэ.







*Зураг № 23 Ургамлын мониторинг судалгааны явц*





*Зураг № 24 Галын сараағ ШТС талбайд байршуулсан байдал, уурхайн техник бүрд галын аюулгүй байдлыг хангаж буй байдал*

## 4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

2024 онд 2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн. 2024 онд 4 га /40250м$^2$/ талайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн байна.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагтайгаа тохиролцсоны дүнд 200ш модыг заасан чиглэлд тарихаар төлөвлөсөн. Төлөвлөгөний хүрээд өрөл 100ш, үхрийн нүд 50ш, улаалзгана 50ш нийт 200ш жимсний модны суулгац худалдан авч мод тарих, модны нүх ухах гээд нийт 3,7сая төгрөгний ажлыг хийж гүйтгэсэн болно. Төлбөрийн баримтыг хавсралт хэсэгт оруулав.

*Хүснэгт № 6 Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарьсан модны төрөл*

| Модны төрөл | Тоо /ш/ | Нэгжийн үнэ /төг/ | Нийт үнэ /төг/ |
|---|---|---|---|
| Өрөл мод | 100 | 15000 | 1500000 |
| Үхрийн нүд | 50 | 12000 | 600000 |
| Улаалзгана | 50 | 12000 | 600000 |
| Модны нүх ухах, тарих | 200 | 5000 | 1000000 |

| | | | |
|---|---|---|---|
| Нийт үнэ | | | 3700000 |



*Зураг № 25 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил*




*Зураг № 26 Дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал*



*Зураг № 27 Уурхайн олборлолтын явц 2024.09.29*




*Зураг № 28 Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал 2024.10 сар*

## 5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“ХОТУ” ХХК нь 2024 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баяндун сумаас өгсөн чиглэлийн дагуу сумын төвд байрлах “Наранбулаг”-ийн эхийг хашаалж хамгаалахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу “Наранбулаг”-ийн эхийг хашаалах зургийн дагуу хашааг хийж орон нутагт хүлээлгэж өгсөн.




*Зураг № 29 Хашааны зураг төсөл*




*Зураг № 30 Хашааны ажлын явц*







*Зураг № 31 Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийсэн хашаа*

## 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

# 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

# 8. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБ хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ.

Мөн төсөл хэрэгжих шороон ордын ашиглалтын явцад химийн тэсэрч дэлбэрэх химийн бодис ашиглаагүй.

# 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Баяндун сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлыг хэрхэн ялган ангилах талаар сургалт зохион байгуулсан. Техникээс гарах хаягдал тосыг “Хай би Ойл”ХХК-тай гэрээ байгуулан нийлүүлэн ажиллаж байна. Гэрээ болон тусгай зөвшөөрлийг хавсралтаар оруулав.

*Хүснэгт № 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт*

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Хаягдлаас гарах дахин ашиглагдах түүхий эдийг ялгах, тушаах | Уурхайн дарга | Хог хаяглыг дахин ашиглагдах болон аюултай гэж ангилан хурааж байна. Ангилан ялгасан хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлж байна. Хог хаягдлын ангилсан зураг оруулав. |
| 2. | Хог хаягдлын гэрээгээ Баяндун сумтай байгуулах | Уурхайн захирал | Төлбөр төлсөн баримт, хог хаягдлын гэрээ, Сумын байгаль хамгаалагчын тодорхойлолтыг тус тус хавсаргав. |
| 3. | Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савнуудыг худалдан авч хог хаягдлын төрлийг хогийн савны гадна бичиж байрлуулна. | Уурхайн дарга | Уурхайн хотхонд хуванцар сав, шил болон лааз, цаасан хаягдлуудыг ялгах тасалгаа бүхий сав байршуулав. Зураг оруулав. |




*Зураг № 32 Хуурай хог хаягдлын цэг*




*Зураг № 33 Хуванцар хаягдал, ашигласан акумляторыг ангилдаг байдал*




*Зураг № 34 Шатах тослох материалын хаягдал*




*Зураг № 35 Хаягдал дугуй*




*Зураг № 36 Хатуу хог хаягдлаа ачиж буй байдал*




*Зураг № 37 Хаягдал тосыг цуглуулж буй байдал*

Ажилчдын шингэн хог хаягдлыг ариутгах журмаар “Тамир-ЭМ” бэлдмэлийг ашигласан бөгөөд уурхайн үйлчлэгчид хэрэглэх зааварчилгааг хүргэсэн.

## 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 9 дүгээр сард Байгаль орчны зөвлөх үйлчилгээний эрх бүхий “Газарчандмань”ХХК-аар хийлгүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн.

*Хүснэгт № 8 Орчны хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн ажил*

| Хяналт шинжил-гээний дээж | Хяналт шинжилгээний үзүүлэлт | 2024 оны хяналт шинжилгээний хэлбэр, зардал | Хяналт шинжилгээ явуулах хугацаа | Хяналт шинжилгээ явуулах байршил | Хяналт шинжилгээ хийх багаж. холбогдох стандарт |
|---|---|---|---|---|---|
| **Агаар** | Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, $NO_2$. $SO_2$ CO -ын агууламж, дуу чимээ | Агаарын шинжилгээний 2 цэгт 2 удаа хэмжилт хийлгэнэ. | 2024.09 сард | Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон | Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016 |
| **Ус** | Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг хүнд металлын шинжилгээнд өгөх | Унд ахуйн ус Бактериологи<br>Усны химийн ерөнхий шинжилгээ<br>Цэврийн болон бохирын нуур<br>Хүнд металл | 2024.09 сард | Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, | Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Хөрс** | Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери | шимт хөрсний овоолго, засварын газар, ШТС орчим | 2024.09 сард | шимт хөрсний овоолго, засварын газар, ШТС орчим | MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл<br>MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох<br>MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам<br>MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх |

## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

*Хүснэгт № 9 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт*

| № | Хийгдэх ажил | Хариуцах эзэн | Биелэлт |
|---|---|---|---|
| 1. | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх | Компанийн захирал<br>Байгаль орчны мэргжилтэн | Байгаль орчны нийцлийн аудитыг мэргэжлийн эрх бүхий “Тэрх хүрэм”ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Ажлын явцын талаар хавсралтад оруулав. |
| 2. | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх | | Дорнод аймгийн БОГазарт 11 сарын 01 багтаан хүргүүлэв. |
| 3. | Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих | | Байгаль орчны ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулах, төлбөр төлөх ажлыг цаг алдахгүй гүйцэтгэж байсан. |



*Зураг № 38 Байгаль орчны аудит*ын явц

## 12. ДҮГНЭЛТ

2024 онд Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайнд 2 га-д техникиийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд 4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баяндун сумаас өгсөн чиглэлийн дагуу сумын төвд байрлах “Наранбулаг”-ийн эхийг хашаалж хамгаалахаар төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу булгийн эхийг хашаалах ажлыг зургийн дагуу хийж орон нутагт хүлээлгэж өгсөн.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон нутагтайгаа тохиролцсоны дүнд 200ш модыг заасан чиглэлд тарихаар төлөвлөсөн. Төлөвлөгөний хүрээд өрөл 100ш, үхрийн нүд 50ш, улаалзгана 50ш нийт 200ш жимсний модны суулгац худалдан авч мод тарих, модны нүх ухах гээд нийт 3,7сая төгрөгний ажлыг хийж гүйтгэсэн болно.

2024 оны байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг 9-р сард байгаль орчны үнэлгээ, зөвөлгөөний эрх бүхий “Газарчандмань”ХХК-аар гүйцэтгүүллээ.

Байгаль орчны нийцлийн аудитыг мэргэжлийн эрх бүхий “Тэрх хүрэм”ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.

Хог хаягдлын гэрээгээ Баяндун сумтай байгуулан сумын төвлөрсөн цэгт хог хаягдлаа төвлөрүүлж байгаа бөгөөд техникийн хаягдал тосыг тусгай зөвшөөрөлтэй “Хай би ойл” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Уурхайн ус ашиглах гэрээг Онон-Улз голын сав газартай байгуулан ажиллаж байна.

Монгол улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарт тоосны агууламж PM 10, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл зэрэг үзүүлэлт нь 24 цагийн дундаж

үзүүлэлтээр үзсэн. Хэмжилт хийсэн газруудад агаарын техникийн ерөнхий шаардлага стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Уурхайн ундны усанд ундны усны стандартад нийцэж байгаа эсэх, мөн бактерлогийн шинжилгээг “Монгол ус”ТӨҮГ-ийн усны лабораторид шинжлүүлсэн.

Уурхайн засварын газар, ШТС-ын газрын хөрсийг “Ханлаб”ХХК-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд хүнд металлын 28 элементийг үзүүлж хүлцэх агууламжтай харьцуулсан бөгөөд хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй болно.

Шимт хөрсний овоолгоос дээж авч ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн Хөрсний лабораторид хөрсний химийн үндсэн шинж, хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлуулсан.

**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН**
**ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИ**
**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, 11-р хороолол
**Утас:** +976 99141955
**E-mail:** soillab.IGG@gmail.com

## Хөрсний задлан шинжилгээний дүн

**Дээж авсан газрын нэр:** Дорнод аймаг, Баяндун сум, MY-003108 тоот алтны шороон орд

**Дээж шинжлүүлсэн байгуулага, хувь хүн:** "ХОТУ" ХХК

**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сар 14

### *Хөрсний химийн үндсэн шинж*

| № | Дээжний дугаар | Гүн, см | $pH_{H_2O}$ (1:2.5) | $CaCO_3$ % | Ялзмаг % | $EC_{2.5}$ dS/m | Хөдөлгөөнт, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | $P_2O_5$ | $K_2O$ |
| 1 | Шимт хөрс | өнгөн | 8.90 | 0.00 | 2.360 | 0.158 | 1.72 | 20.4 |

### *Хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Дээжний координат | Гүн, см | Ширхэгийн хэмжээ, % ( мм-ээр) | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Элс (2-0.05мм) | Тоос (0.05-0.002мм) | Шавар (< 0.002мм) |
| 1 | Шимт хөрс | өнгөн | 70.0 | 16.0 | 14.0 |

**Товч дүгнэлт:**

Хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанараар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн агууламжаар дунд зэрэг, механик бүрэлдэхүүн элсэнцэр. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж.

**Шинжилгээний арга**

pH, EC-MNS ISO 10390:2001- Ионометр, кондуктометр
$CaCO_3$-Кальциметр (10% HCl)
Ялзмаг-Тюрин (Walkley & Black)
Хөдөлгөөнт фосфор, кали-Спектрофотометр, Дөлөн фотометр-Мачигин (1% $(NH_4)_2CO_3$)
Хөрсний механик бүрэлдэхүүн-Гидрометрийн арга

Хөрсний лабораторийн эрхлэгч, доктор (Ph.D) ________ Х.Золжаргал

*Хавсралт № 1 Шимт хөрсний дээжийн хариу*

KhanLab
*Чанар Хурд Дэвшил*

**ХАНЛАБ ХХК**
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17-р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
http://www.khanlab.mn

ilac-MRA MNAS Accreditation system

## ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: **2024/1711-1**
ЗАХИАЛАГЧИЙН НЭР: **ХОТУ ХХК** ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: **Хөрс, 2**
ОБЪЕКТ: Дорнод аймаг, Баяндун сум, алтны шороон орд, MV-003108

| № | ЛАБОРАТОРИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | ЭЛЕМЕНТ, % | | | | | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Na | Ca | Mg | K | $Fe_{нийт}$ | As | Ba* | Be | Bi | Cd |
| 1 | Л-17541 | ШТС | хөрс | 1.53 | 1.09 | 0.72 | 1.44 | 4.84 | 14.65 | 277.3 | 1.47 | <10.0 | <1.0 |
| 2 | Л-17542 | Засварын талбай | хөрс | 0.39 | 0.06 | 0.03 | 1.29 | 1.72 | <5.0 | 99.29 | <1.0 | <10.0 | <1.0 |
| | | *MNS5850:2019* | | - | - | - | - | - | *20.00* | - | - | - | *3.00* |

| № | ЛАБОРАТОРИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Co | Cr | Cu | La | Li | Mn | Mo | Ni | P | Pb |
| 1 | Л-17541 | ШТС | хөрс | 34.92 | 125.9 | 62.49 | 12.82 | 11.79 | 893.4 | <5.0 | 44.23 | 727.6 | 21.42 |
| 2 | Л-17542 | Засварын талбай | хөрс | 8.81 | 33.30 | 20.70 | <5.0 | <5.0 | 123.1 | <5.0 | 13.01 | 231.9 | 10.73 |
| | | *MNS5850:2019* | | *50.00* | *150.0* | *100.0* | - | - | - | *5.00* | *150.0* | - | *100.0* |

| № | ЛАБОРАТОРИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ДУГААР | ДЭЭЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ | ЭЛЕМЕНТ, мг/кг | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Sb | Se | Sr* | Ti | V | Y | Zn | Zr* |
| 1 | Л-17541 | ШТС | хөрс | 11.66 | 11.90 | 214.4 | 6301 | 219.7 | 9.01 | 78.33 | 34.94 |
| 2 | Л-17542 | Засварын талбай | хөрс | <10.0 | <5.0 | 15.04 | 2310 | 65.53 | 1.06 | 24.16 | 28.24 |
| | | *MNS5850:2019* | | - | *10.00* | *800.0* | - | *150.0* | - | *300.0* | - |

Чанарын менежер: Д. Пүрэвжаргал

**Тайлбар:** *-Бүрэн задрахгүй. /Хагас тоон утга/ Шинжилгээнд ирүүлсэн дээжийг 1 сар хүртэл хугацаагаар хадгална.

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна. Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: **2024.10.01** ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: **хийгдсэн.**
ШИНЖИЛСЭН ОГНОО: **2024.10.17** ХУУДАСНЫ ТОО: 1

***Хамтран ажилласан танд талархлаа.***

Хуудас 1-1

*Хавсралт № 2 ШТС болон засварын талбайн хөрсний хүнд металлын шинжилгээний дүн*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР

**ХЯНАЛТЫН ТӨВ ЛАБОРАТОРИ**
*/Central inspection laboratory/*

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-хороо, Чингүнжавын гудамж Утас 70180075

**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС**
*/Test result of accredited laboratory/*

MNAS
**TL 092**
***MNS ISO 17025***

**Захиалагчийн нэр** */Customer name/*: **“Хоту”ХХК**

| **Дээжний дугаар** */Test number/* | **Дээжний хаяг, байршил** */Sample location/* | | | **Уст цэгийн төрөл** */Type of water/* | |
|---|---|---|---|---|---|
| № 1505 | Дорнод аймаг, Баяндун сум, Алтны шороон орд, Бохир нуурын ус | | | Бохир ус | 49º29'49'' 113º27'1'' |
| **Дээжний тоо, хэмжээ** */Quantity of the sample/* | **Дээж хүлээн авсан огноо** */Date receipt/* | **Шинжилсэн огноо** */Analyzing date/* | **Хэвлэсэн огноо** */Printed date/* | **Техникийн шаардлага** */ Technical requirements/* **MNS 4943:2015** | |
| 1.5л / 1.5L / | 2024.10.01 | 2024.10.08 | 2024.10.16 | **Шинжилгээний аргын стандарт** */Test method/* **MNS ISO 11885:2011 /ICP/** | |

